



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2024 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 230

Улаанбаатар хот

**Хорооны тогтоолын хавсралтын холбогдох хэсэгт  
өөрчлөлт оруулах тухай**

Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup>.1.11, 11.5, тус хорооны 2024 оны 171 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Радио давтамжийн 2540-2550МГц/2660-2670МГц-ийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 4G/LTE системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийн 2.4.2, 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны 171 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Радио давтамжийн 2540-2550МГц/2660-2670МГц-ийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 4G/LTE системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын баримт бичиг”-т заасан сонгон шалгаруулалтын төсөл хүлээн авах хугацааг 14 хоногоор сунгасугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сонгон шалгаруулалтын оролцогчдод мэдэгдэхийг Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газар /З.Амгалан/-т даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР